

ЕРӨНХИЙ МЭРГЭЖЛИЙН САЛБАР ЗӨВЛӨЛИЙН МЭРГЭЖЛИЙН ЗЭРЭГ ОЛГОХ, ХАМГААЛАХ ЖУРАМ

Нэг. Ерөнхийзүйл

1.1 Энэхүү журмын зорилго нь анагаах ухааны дээд, дунд боловсролтой өрх, сум, тосгоны эрүүл мэндийн төвд их эмч, бага эмч-сувилагч чиглэлээр эмчлэх, сувилах эрхтэй ажиллаж буй хүний их эмч, бага эмчид мэргэжлийн зэрэг олгох, хамгаалахтай холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

Хоёр: Тусгай шалгуур үзүүлэлт

2.1. Ахлах зэрэг горилох эмч дараах тусгай шалгуурыг хангасан байна.

2.1.1.Эмнэлгийн мэргэжилтэнд мэргэжлийн зэрэг олгох, журмындагуу мэргэжлийн байгууллагаас тодорхойлолт авсан байх /Харьяа дээд шатны байгууллагын хариуцсан албан тушаалтанаас авах/

2.1.2 Их эмч нь өрхийн анагаах ухаанаар төрөлжсөн мэргэшил эзэмшсэн байх

2.1.3. Ахлах зэрэг горилох их эмч дангаар буюу бусадтай хамтран 3-аас доошгүй өгүүлэл, илтгэл бэлтгэж, нийтлүүлсэн болон хэлэлцүүлсэн байх,

2.1.4. Бага эмч нар өгүүлэл бичиж нийтлүүлэх, илтгэл бэлтгэж хэлэлцүүлэхэд Биечлэн оролцсон байх

2.1.5. Ажилласан жилдээ 2-оос доошгүй мэргэжигчийг дагалдуулан сургаж, дадлагажуулсан байх

2.1.6. Иргэдэд эрүүл аж төрөх ёсыг төлөвшүүлэх, эрүүл зан үйлийг хэвшүүлэх. Эрсдэлт хүчин зүйлээс сэргийлэх чиглэлээр эрүүл мэндийн боловсрол олгохсургалтыг зохион байгуулж, үр дүнг тооцсон баримтыг хавсаргах

2.1.7. Үйлчлэх хурээний иргэдийн сэтгэл ханамжийн судалгааны дүнг харьяа дээд шатны байгууллага, хөндлөнгийн этгээдээр гаргуулж тус тус хавсаргах

2.1.8. Ёс зүйн болон мэргэжлийн алдаа гаргаагүй болохыг нотолсон баримтыг хавсаргах

2.2. Тэргүүлэх зэрэг горилох эмч дараах тусгай шалгуурыг хангасан байна.

2.2.1. Энэхүү журамд заасан материалыг бүрдүүлэх

2.2.2. Их эмч нь өрхийн анагаах ухаанаар төрөлжсөн мэргэшил эзэмшсэн байх

2.2.3. Тэргүүлэх зэрэг горилох их эмч дангаар буюу бусадтай хамтран 5-аас доошгүй

өгүүлэл, илтгэл бэлтгэж, нийтлүүлсэн болон хэлэлцүүлсэн байх

2.2.4. Ажилласан жилдээ 4-оос доошгүй мэргэжигчийг дагалдуулан сургаж, Дадлагажуулсан байх

2.2.5. Ёс зүйн болон мэргэжлийн алдаа гаргаагүй болохыг нотолсон баримтыг хавсаргах

2.2.6. Иргэдэд эрүүл аж төрөх ёсыг төлөвшүүлэх, эрүүл зан үйлийг хэвшүүлэх.

Эрсдэлт хүчин зүйлээс сэргийлэх чиглэлээр эрүүл мэндийн боловсрол олгох сургалтыг зохион байгуулж, үр дүнг тооцсон баримтыг хавсаргах

2.2.7. Үйлчлэх хүрээний иргэдийн сэтгэл ханамжийн судалгааны дүнг харьяа дээд шатны байгууллага, хөндлөнгийн этгээдээр гаргуулж туст усхавсаргах

2.3. Зөвлөх зэрэг горилох эмч дараах тусгай шалгуурыг хангасан байна.

2.3.1. Их эмч нь өрхийн анагаах ухаанаар төрөлжсөн мэргэшил эзэмшсэн байх

2.3.2. Зөвлөх зэрэг горилох ихэмч дангаар буюу бусадтайхамтран 8-аас доошгүй өгүүлэл, илтгэл бэлтгэж, нийтлүүлсэн болон хэлэлцүүлсэн байх

2.3.3. Ажилласан жилдээ 6-оос доошгүй мэргэжигчийг дагалдуулан сургаж, Дадлагажуулсан байх

2.3.4. Ёс зүйн болон мэргэжлийн алдаа гаргаагүй болохыг нотолсон баримтыг хавсаргах

2.3.5. Иргэдэд эрүүл аж төрөх ёсыг төлөвшүүлэх, эрүүл зан үйлийг хэвшүүлэх.

Эрсдэлт хүчин зүйлээс сэргийлэх чиглэлээр эрүүл мэндийн боловсрол олгох сургалтыг зохион байгуулж, үр дүнг тооцсон баримтыг хавсаргах

2.3.6. Үйлчлэх хүрээний иргэдийн сэтгэл ханамжийн судалгааны дүнг харьяа дээд шатны байгууллага, хөндлөнгийн этгээдээр гаргуулж тус тус хавсаргах

2.3.7. Удирдах ажлыг 5-аас доошгүй жил хийсэн байх, мэргэжлийн чиглэлээр Хамт олон, харьяа дээд шатны байгууллагаар тус тус тодорхойлуулсан байх.